




*Үндэсний Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан*

“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”



**Хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.**

2018 он

## АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p>	<p>Товчилсон үгийн тайлбар _____ 3          Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй _____ 4</p>
<p>Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p><b>Бүлэг 1. Тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөл нь холбогдох эрх зүйн шалгуурыг хангахгүй байна.</b></p>
<p>Дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p>	<p>1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаж байгаа ч зарим төсөл арга хэмжээний ашиглалтын зардлын тооцоог гаргаж төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй байна ____ 5</p>
<p>Аудитын менежер Ц.Лүндэгмаа</p>	<p>1.2. Зураг төсөл нь бэлэн болоогүй, зураг төслийг экспертизээр батлуулаагүй төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын төсөв баталсан байна _____ 7</p>
<p>Аудитор Б.Тунгалагуяа Аудитор Т.Мөнхтогтох</p>	<p><b>Бүлэг 2. Худалдан авах ажиллагааны үр нөлөөг сайжруулах хэрэгтэй байна.</b></p>
<p>2018 оны 6 дугаар сар</p>	<p>2.1. Захиалагч чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлыг тендерийн баримт бичигт тусгасан байна _____ 9</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052-2734 дугаарын факсаар харилцана уу</p>	<p>2.2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч гүйцэтгэгч хэд хэдэн тендерт оролцож шалгарснаас ТАХ-г гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, зарим ажлыг чанаргүй гүйцэтгэжээ _____ 10</p> <p><b>Бүлэг 3. Захиалагчийн хяналт сул байгаагаас зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.</b></p>
<p>ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр</p>	<p>3.1. Захиалагч гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцон ажиллаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөө, үр өгөөжийг бууруулж байна ____ 12</p>
	<p>3.2. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл бодитой, хугацаандаа хэрэгжээгүй байхад нийт 450.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна _____ 14</p> <p>3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сул, хэрэгжсэн зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй байна _____ 16</p> <p>Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт _____ 18</p> <p><b>БҮЛЭГ 4.</b></p> <p>Ерөнхий дүгнэлт _____ 19          Ерөнхий зөвлөмж _____ 20          Холбогдох байгууллагын санал _____ 21          Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар _____ 27</p>

## Товчилсон үгийн тайлбар

<b>ААНБ</b>	Аж ахуй нэгж байгууллага
<b>АТҮТ</b>	Авто тээврийн үндэсний төв
<b>БНБД</b>	Барилгын норм ба дүрэм
<b>ГА</b>	Гүйцэтгэлийн аудит
<b>ГИХГ</b>	Гадаадын иргэн харьяатын газар
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
<b>ДГА</b>	Дорноговь аймаг
<b>ЗАА</b>	Захирагчийн ажлын алба
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>ОНХО</b>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ОНӨХХК</b>	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ТАХ</b>	Төсөл арга хэмжээ
<b>ТББ</b>	Тендерийн баримт бичиг
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ХМХА</b>	Хилийн мэргэжлийн хяналтын алба
<b>ХО</b>	Хөрөнгө оруулалт
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ЦДАШ</b>	Цахилгаан дамжуулах агаарын шугам
<b>ШШГА</b>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### ***Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:***

Үндэсний аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийв.

### ***Аудитын зорилт:***

“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийнэ.

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй, оновчтой эсэх;
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа үр дүнтэй эсэх;
3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнтэй эсэх.

### ***Хамарсан хүрээ:***

Тус аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Замын-Үүд сумын ЗДТГазар, бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

### ***Арга зүй:***

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын аргазүйг ашиглан холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд, санхүүгийн албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, судлах, дүн шинжилгээ болон харьцуулалт хийх, тулган баталгаажуулах зэрэг аргазүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмжийг өглөө.

## Бүлэг 1

Тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөл нь холбогдох эрх зүйн шалгуурыг хангахгүй байна.

1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаж байгаа ч зарим төсөл арга хэмжээний ашиглалтын зардлын тооцоог гаргаж төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргаагүй байна.

1.1.1. Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын хурлаар 2017 оны хөрөнгө оруулалтаар 28 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,633.6 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Энэхүү төсөвт 2 удаа өөрчлөлт оруулж 28 төсөл арга хэмжээнд 5,331.0 сая төгрөг, замын сангийн санхүүжилтээр 13 төсөл арга хэмжээнд 639.5 сая төгрөг, нийт 44 төсөл арга хэмжээнд 5,970.5 сая төгрөг зарцуулахаар тодотгон баталжээ.

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Хүснэгт №1
			Мөнгөн дүн /сая.төг/
1	Шинэ хөрөнгө оруулалт	17	3,511.3
2	Их засвар	3	1,060.0
3	Тоног төхөөрөмж	10	299.5
4	ТЭЗҮ, зураг төсөл	3	120.0
5	Өмнөх оноос шилжих	8	979.7
	<b>Нийт дүн</b>	<b>41</b>	<b>5,970.5</b>

Замын-Үүд сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын хурлаар 2017 оны сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 26 төсөл арга хэмжээнд 751.9 сая төгрөг баталсан байна. Сумын ИТХ-ын 2017 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 05/01 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтад 11 төсөл арга хэмжээг нэмж нийт 747.3 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийсэн нь өмнөх дүнгээс 4.6 сая төгрөгөөр буурсан байна.

Мөн Замын-Үүд сум 2017 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн 07/01 дүгээр тогтоолоор 15 төсөл арга хэмжээг нэмж нийт 1,102.5 сая төгрөгөөр буюу 355.2 сая төгрөг нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна.

Аймаг, орон нутагт хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудыг “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тухайн оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан баталсан бол Замын-Үүд сумын төсвөөс хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 36 төсөл арга хэмжээ буюу 56.2 хувь нь хөгжлийн бодлогын баримт бичиг болон сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020 он/, Замын-Үүд сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд орсон ажлууд байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>1</sup> дэх заалтыг зөрчиж орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагад хөрөнгө худалдан авахад зориулж 140.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төсөв баталсан байна. Үүнд:

- АТҮТөвд автомашин авахад - 9,9 сая төгрөг;
- ШШГАлбанд автомашин авахад - 12,5 сая төгрөг;
- Аймгийн Татварын хэлтэст автомашин худалдан авахад - 20.0 сая төгрөг;
- Цагдаагийн газарт хурд хэмжигч авахад - 29,2 сая төгрөг;
- Цагдаагийн пост барихад - 69,1 сая төгрөг.

Мөн Замын-Үүд сумын хөрөнгөөр улсын төсвөөс санхүүждэг 12 байгууллагад 607.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн нь нийт хөрөнгө оруулалтын 58.3 хувийг эзэлж байна. Тухайлбал:

- Тагнуулын газар - 5.0 сая төгрөг;
- Сум дундын Прокурорын газар - 5.0 сая төгрөг;
- Сум дундын Шүүхийн газар - 7.9 сая төгрөг;
- Чандмань-Бадрал ОНӨХХК - 8.0 сая төгрөг
- Нэгдсэн эмнэлэг - 28.0 сая төгрөг;
- ХМХА - 32.3 сая төгрөг;
- Ургах наран цэцэрлэг, 1 дүгээр цэцэрлэг болон 1 дүгээр сургууль - 35.1 сая төгрөг;
- Сум дундын Цагдаагийн хэлтэс - 60.6 сая төгрөг;
- Хилийн 0108-р анги - 69.0 сая төгрөг;
- ГИХ-н Дорноговь дахь газар - 356.1 сая төгрөг.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагаа урьдчилан судалж, үнэлж, нэн тэргүүний шаардлагатай төсөл арга хэмжээг тодорхойлох, зөвхөн санхүүгийн дэмжлэг хүссэн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх бус зорилго зорилттойгоо нийцүүлэх, үр ашиг, үр нөлөөг нь тооцож төлөвлөх шаардлагатай байна.

1.1.2. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ямар байгууллага эзэмшиж ашиглах, үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх талаар урьдчилан судлаагүйгээр дараах төсөл арга хэмжээнүүдэд ИТХ-аар төсөв батлуулж Төсвийн тухай хуулийн 29.2<sup>2</sup> дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Сайншанд сумын 4 дүгээр багт байрлах 24.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Усан сангийн худаг, 76.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Халуун усны барилгыг 2017 оны 8, 10 дугаар сард улсын комисс ашиглалтанд хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл хөрөнгийн ашиглагч байгууллага тодорхой бус, ашиглалтгүй байгаа нь уг хөрөнгийн үр ашиг, өгөөжийг бууруулж байна.
- Замын сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн Цагдаагийн газрын Замын цагдаагийн постын барилга нь шалнаасаа халдаг бөгөөд гэрэл цахилгааны зардлын төсөв шийдэгдээгүйгээс зарим өрөө тасалгааг ашиглаагүй байна.

Иймд ашиглагч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан судлаж, ашиглалтын зардлыг тодорхойлсны үндсэн дээр үр ашиг, үр өгөөжтэй төсөл арга хэмжээг төлөвлөх хэрэгтэй байна.

<sup>1</sup>Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

<sup>2</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



## 1.2. Зураг төсөл нь бэлэн болоогүй, зураг төслийг экспертизээр батлуулаагүй ажлыг төлөвлөж, төсөв батлуулсан байна.

1.2.1. Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-д шинээр баригдах барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, үр ашгийн тооцоо зэрэгт үндэслэн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөөр заасан байдаг.

Гэтэл аймгийн ИТХ-аар зураг төсөл нь бэлэн болоогүй, зураг төсөл нь экспертизээр батлагдаагүй 3 төсөл арга хэмжээнд 2,138.4 сая төгрөгийн төсөв батлуулсан байна. Тухайлбал:

- *Эрдэнэ сумын ААНБ, айл өрхийг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажил 326.4 сая төгрөг;*
- *Сайншанд сумын 6-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга 400.0 сая төгрөг;*
- *Усан спорт сургалтын төвийн барилга 1,412.0 сая төгрөг.*

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>3</sup>, Барилгын тухай хуулийн 24.1.1<sup>4</sup>, 25.2.5<sup>5</sup>, 37.1.3<sup>6</sup> дахь заалтуудыг тус тус зөрчиж байгаа нь төлөвлөлт үндэслэлгүй болох, төсөл арга хэмжээ гэрээнд заагдсан хугацаанд ашиглалтанд орохгүй байх, ажил чанаргүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эрдэнэ сумын ЗДТГазар нь 2017.06.05-нд Мон-Кузбасс ХХК-тай дулаан, цэвэр бохир усны шугамд холбох зураг төсөл боловсруулах ажлын гэрээг байгуулсан ба зураг төслийг магадлалаар оруулан баталгаажуулаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 13.2<sup>7</sup> дахь заалт, аймгийн Засаг даргатай байгуулсан төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээний 4.2-т "халаалтын зуух, цэвэр бохир ус, дулааны шугам сүлжээг зохих стандарт, норм дүрмийн дагуу батлагдсан зураг төсвийн дагуу барьж байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, батлуулахдаа зураг төсөв нь хийгдсэн ажлуудыг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж батлах нь зүйтэй байна.

1.2.2. Барилгын тухай хуулийн 23.2<sup>8</sup>-д заасны дагуу шинэ барилга, дулаан, цэвэр усны шугам сүлжээний ажлуудыг гүйцэтгэх ТАХ-ний газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл нь дараах ажлуудад олгогдсон байна.

- *Иргэдийн хөгжлийн төв, усан спорт, сургалтын төвийн барилгад газрын эзэмшүүлэх гэрээ, цэвэр бохир усаар хангах техникийн нөхцөл*
- *Айраг сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөл*
- *Сайншанд сумын Өндөр довын усан сангийн барилга*
- *2,4 дүгээр багийн Халуун усны барилга*

<sup>3</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>4</sup> батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

<sup>5</sup> энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

<sup>6</sup> барилга байгууламжийн техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах, барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 22, 23, 26 дугаар зүйлд заасны дагуу авч, түүнд заасан нөхцөлийг биелүүлэх;

<sup>7</sup> Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ;

<sup>8</sup> Баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна;

- Эрдэнэ сум ЦДАШ, дулаан, цэвэр бохир усны шугамын ажил

1.2.3. Төсвийн тухай хуулийн 58.4.10-д “Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийнэ” гэж заажээ. Гэтэл Замын-Үүд сумын ИТХ-аас хөрөнгө оруулалтын шинж чанартай бус нийт 13.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг баталсан байна. Тухайлбал:

- Цаг уурын мэдээ мэдээллийн самбар худалдан авахад /самбар байршуулах зардал/ 0.7 сая төгрөг;
- Төв талбай дээрх гацуурын модны чимэглэл саа худалдан авахад 1.0 сая төгрөг;
- “Цэмцгэр Замын-Үүд” аяны шагнал урамшууллын төсөвт 1.4 сая төгрөг;
- Сумын ИТХ-ын автомашины засварт 2.1 сая төгрөг;
- Соёмбо хотхоны 150, 151 дүгээр байрны дулааны дэмжлэгт /нүүрс/ 8.0 сая төгрөгийг тус тус баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт

## Бүлэг 2

Худалдан авах ажиллагааны үр нөлөөг сайжруулах хэрэгтэй байна.

**2.1. Захиалагч чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлыг тендерийн баримт бичигт тусгасан байна.**

2.1.1. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Засаг даргаар, Замын-үүд сумын ЗАА нь сумын Засаг даргаар 2017 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулан ТБОНӨХБАҮХАХТухай хуулийн 48.5<sup>9</sup>-д заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад байршуулж нийтэлсэн байна.

2.1.2. Аймагт зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаагаар тайлант онд нийт гэрээний 13 буюу 32.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын, 14 буюу 35 хувийг харьцуулалтын, 4 буюу 10 хувийг зөвлөх үйлчилгээ, 9 буюу 22.5 хувийг шууд гэрээ байгуулах аргаар тус тус шалгаруулжээ.

Замын-Үүд суманд худалдан авах ажиллагааны 6.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын, 27.9 хувийг харьцуулалтын аргаар, 4.9 хувийг олон нийтийн оролцоотой ХАА, 60.7 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулжээ.

Тендер шалгаруулалтын үнэлгээний хороо, гишүүдийн ирц бүрдлээс хамааран нээлттэй тендерийг 30 хоног, харьцуулалтын тендер шалгаруулалтыг урилга илгээснээс өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтоон, үнэлгээ хийж дүгнэлтийг захиалагчид хүргүүлэн ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2<sup>10</sup>-т заасны дагуу тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулсан байна.

<sup>9</sup> Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ;

<sup>10</sup> Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулсан байна.



Замын-Үүд сум нь ажил үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй байхад 1 дүгээр цэцэрлэгийн дулааны шугам шинээр татах ажлыг 2017 оны 8 дугаар сарын 10-аас эхлэн гүйцэтгэж 12 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгчээ.

Гэтэл дээрх ажилд Замын-Үүд сумын ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 07/01 тоот тогтоолоор 20.0 сая төгрөгийн төсөв баталсан ба сумын Засаг даргын 2017.12.11-ний өдрийн А/357 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй Үнэлгээний хороо байгуулсан байна.

Дээрх ажлыг Чандмань бадрал ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2017.12.20-ны өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.5<sup>11</sup>-д заасныг зөрчиж төсөв батлагдаагүй байхад ажлыг эхлүүлсэн байна.

**2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч гүйцэтгэгч хэд хэдэн тендерт оролцож шалгарснаас ТАХ-г гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, зарим ажлыг чанаргүй гүйцэтгэжээ.**

2.2.1. Аймаг, сумын ИТХ-аас батлагдсан ажлуудад худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчлөөгүй байна.

2.2.2. Аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтаар нээлттэй тендер зарлагдсан 3, харьцуулалтын аргаар зарлагдсан 5 тендер хүчингүй болсон бөгөөд ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29.3-д заасны дагуу удаахь “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой шууд гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №2

№	Төсөл арга хэмжээний нэр	Тендер шалгаруулалт
1	Айраг сумын Эрүүл мэндийн төвийн барилга	Нээлттэй тендер
2	Замын-Үүд сумын 1.4 дүгээр багийн нийтийн орон сууцны засварын ажил	
3	Сайншанд сумын 5.7 дугаар багийн нийтийн орон сууцны засварын ажил	
4	Сайншанд сумын Өндөр довын Усан сан	Харьцуулалтын арга
5	Хөвсгөл сумын ЗДТГазар автомашин	
6	Дэлгэрэх сумын ЗДТГазар автомашин	
7	Багийн дарга нарыг унаажуулах	
8	Нэгдсэн эмнэлгийн гадна авто зогсоол	

2.2.3 ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу нийт 5 тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд гомдол гарсан байна. Сангийн яам дээрх гомдлыг шийдвэрлэн тендертэй холбоотой хариу хариу мэдэгдлийг аймгийн Орон нутгийн өмчийн албанд хүргүүлсэн байна.

Тендерт шалгарсан зарим компаниуд хөрөнгө, техник, хүн хүчний дутагдалтай, өөр хөрөнгийн үүсвэрээр санхүүжигдэж буй ажлуудыг зэрэг гүйцэтгэж байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ажлын гэрээний хугацаа хэтрэх, хугацааг сунгах, төсөл арга хэмжээг дутуу, чанаргүй хийж гүйцэтгэх зэргээр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

<sup>11</sup>. Тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх;

- Оточ буян ХХК улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4 ажил хийж гүйцэтгэсний 2 ажлыг дутуу, чанаргүй, 1 ажлыг хийж дуусгаагүй байна.
- Сизу ХХК нь ОНХО-аар 2 ажлыг гүйцэтгэсэн ба Эрдэнэ сумын ААНБ, айл өрхийг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажлыг өнөөг хүртэл хүлээлгэж өгөөгүй, гэрээний хугацаа хэтэрсэн байна.
- Замын-Үүд сумын “Замын-Үүд нийтийн аж ахуй үйлчилгээ” ОНӨХХК төв саадны засвар, Соёмбо цогцолборын засварын ажлын хамт 1-р сургуулиас Төмөр замын гал команд хүртэл 410 метр, Дөл буудлын урдуурх 200 метр явган хүний зам барих ажлыг зэрэг гүйцэтгэснээс гэрээний хугацаанд ажлаа хийж чадахгүйд хүрч гэрээг 60 хоногоор сунгуулсан байна.

Замын-Үүд суманд Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 2.2, Төсвийн тухай хуулийн 58.4.7<sup>12</sup>, 58.4.8<sup>13</sup>-д заасныг зөрчиж 3 бүлгээр Сүлд багийн байрны дээврийн засварын ажил, Борхой болон 3-р багийн байрны гадна фасад, дотор засварын нийт 34.2 сая төгрөгийн ажилд олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Борхой болон 3 дугаар багийн 00 өрөөний засвар хийгдээгүй, дээврийн засвар чанаргүй хийгдсэнээс үүдний хэсэгт гоожсон байна.

Улсын хэмжээнд “Цахим-2” төсөл тайлант оны 5 дугаар сараас эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) шинэчлэгдсэн сайтад нийт зарлагдсан 25 тендерээс 7 тендер шалгаруулалтыг хялбаршуулсан цахим хэлбэрээр зарласан байна.

Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 3.2<sup>14</sup>-т заасны дагуу тухайн жилд хэрэгжүүлсэн ХАА-ны төлөвлөгөө, хэрэгжилтийн явцын тухай мэдээлэл, гүйцэтгэл болон цаашид анхаарах санал хүсэлтийг ХАА-ны тайланд тусгаж, тайлан мэдээг хугацаанд нь илгээсэн байна.

<sup>12</sup>. Сум доторхи нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгааг хийх, зохион байгуулах

<sup>13</sup>. Сумын тохижилт, мод ургамал, цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах

<sup>14</sup>. Бичмэл тайланд тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тухай тоо баримт, төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүн, дүгнэлт, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн явцын тухай мэдээлэл, тулгарч байсан бэрхшээл, цаашид анхаарах санал, хүсэлт зэргийг тусгана.

## Бүлэг 3

### Захиалагчийн хяналт сул байгаагаас зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

**3.1. Захиалагч гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцон ажиллаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөө, үр өгөөжийг бууруулж байна.**

3.1.1. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтаар шаардлагад нийцсэн гүйцэтгэгчтэй ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 40.2<sup>15</sup>, 40.3<sup>16</sup>-т заасны дагуу аймагт 40 ТАХ-д нийт 4,980.5 сая төгрөгийн, Замын-Үүд суманд 60 ТАХ-нд 1,041.7 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан байна.

Гүйцэтгэгч компаниуд тендерийн баримт бичигт тусгагдсан ажлыг гүйцэтгэхээр захиалагчтай гэрээ байгуулсан боловч ашиглагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр ажлын даалгаврыг өөрчилж гүйцэтгэсэн, гэрээ байгуулах эрх олгох тухай захирамж дээрх үнийг өөрчилж ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан, техникийн тодорхойлолтын дагуу барааг нийлүүлээгүй байна.

- Замын-Үүд сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан Хилийн шалган нэвтрүүлэх 0108-р ангийн спорт заалны шал хийх 48.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг өөрчилж автомашины граж барьсан байна.
- ОНӨГ-аас Замын-Үүд сумын хуучны нийтийн орон сууцны засварын ажлыг 2 багц болгон тендер зарласан байв. Засварын ажил гүйцэтгэхдээ багц 1-д орсон 131 дүгээр байрны дээврийн засварын ажлын оронд багцуудад ороогүй 24 дүгээр байрны дээвэр зассан, мөн багцуудад ороогүй 109 дүгээр байрны гадна фасад, дулаалгын ажил хийсэн байна.
- Усан спорт, сургалтын төвийн барилгын ажлын нээлттэй тендерт шалгарсан "Баян могод" ХХК-тай гэрээ байгуулж 1018.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх тухай аймгийн Засаг даргын 2017.05.22 өдрийн А/396 тоот захирамж гарсан байтал 2017.06.22-ний өдрийн ажил гүйцэтгэх гэрээнд гэрээний үнэ болох ажлын нийт төсөвт өртгийг 1038.4 сая төгрөгөөр буюу 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн гэрээ байгуулсан байна.

Иймд гэрээ байгуулах эрх олгох тухай захирамжинд тусгасан үнээр ажил гүйцэтгэх гэрээг дахин шинэчлэх албан шаардлага өгөв.

<sup>15</sup>Хамгийн сайн үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно.

<sup>16</sup> Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана.

Дээрх гэрээний асуудлаар баримт материалыг дараагийн онд нягтлан үзэхэд 2018 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад Усан спорт, сургалтын төвийн барилгын ажилд нэмж 100.0 сая төгрөг баталсан байв. Нэмж баталсан төсвийг авч үзэхэд Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрмийн 5.2<sup>17</sup> дахь заалтыг зөрчиж 102.9 сая төгрөгийн нэмэгдэл ажлын төсөв гаргуулсан ба 60.0 сая төгрөгийг ямарч задаргаагүйгээр тусгасан бөгөөд нэмэгдэл ажлын зураг төсөл байхгүй, ямар ажлыг нэмэлтээр хийх нь тодорхой бус байна. /аудитын хугацаанд нэмэгдэл ажлын хэмжилтийн болон, гүйцэтгэлийн зураг төсөл ирүүлээгүй болно/

Мөн нэмэлт ажлын төсвийг боловсруулахдаа нэмэгдэл зардлын дүнг 69.9 хувиар тооцох байтал 72.3 хувиар буюу хүйтний эрчмийн 2 дугаар бүсийн ангилалаар хувийг тооцсон нь Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12<sup>18</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

- Хөвсгөл сумын ЗДТГазар 29.8 сая төгрөгөөр Land cruiser-100 маркийн автомашин худалдан авсан бөгөөд ТББ-ийн техникийн тодорхойлолтонд тусгагдсан зарим үзүүлэлттэй нийцээгүй байна.

Хүснэгт №3

№	Тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн нөхцөл	Автомашинны техникийн тодорхойлолт
1	Үйлдвэрлэсэн огноо-2006	Үйлдвэрлэсэн огноо-2003
2	Монголд орж ирсэн огноо-2007	Монголд орж ирсэн огноо-2003
3	Явсан км 150.0-ээс дээшгүй	Явсан 307.7 км

Засвар хийх барилга байгууламжийг судалж нэн тэргүүний шаардлагатай ажлуудад төсөв хуваарилаагүйгээс ажлын нэр төрөл өөрчлөгдөх, зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу ажлыг хугацаанд нь гүйцэтгэхгүй байх гэрээний үнэ, төсөв тооцоо өөрчлөгдөх үр дагавар бий болж байна.

Аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл арга хэмжээ нь ашиглалтад хүлээн авах комисс бүрдээгүйгээс гэрээт хугацаанаас 46-80 хоногоор хэтэрч ашиглалтанд орсон, 3 төсөл арга хэмжээний гэрээт хугацаа 152-232 хоногоор хэтэрч, гэрээнд заасан хугацаандаа ашиглалтанд ороогүй байна.

Хүснэгт 4

№	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа хэтэрсэн хоног	Ашиглалтанд орсон эсэх
1	Сайншанд сумын 4-р багийн Халуун усны барилга	46	Ашиглалтанд орсон.
2	Эрдэнэ сумын ЦДАШ-ын ажил	46	Ашиглалтанд орсон.
3	Айраг сум Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	80	Ашиглалтанд орсон.
4	Усан спорт, сургалтын төвийн барилга	152	Ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байна.
5	Сайншанд төвийн камержуулах ажил	232	Ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байна.
6	Эрдэнэ сумын ААНБ, айл өрхийг дулаан, цэвэр бохир усны шугамд холбох ажил	277	Ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байна.

<sup>17</sup>.Барилгын төсөвт өртөг нь хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, барилга угсралт, засварын ажлын үнийг тогтоох, гүйцэтгэсэн ажлын төлбөр, тооцоо хийх, тоног төхөөрөмж худалдан авах, түүнийг барилгын талбайд хүргэх болон барилгын нэгдсэн төсөвт тусгагдсан зардлуудыг санхүүжүүлэх үндэслэл болно.

<sup>18</sup> Барилгын төсөв зохиох БНБД 81-95-12 дугаартай нормын хавсралт 7-д "Барилгын засварын ажлын нэмэгдэл зардлыг үе шатны ажлын цалингаас, 1 дүгээр бүсэд 69.9 хувиар тооцно. Энэ нормын хавсралт 10-т Сайншанд хот 1 дүгээр бүсэд хамаарна гэж заасан.

Гүйцэтгэгч компаниудаас захиалагч талд гэрээг сунгуулах тухай хүсэлт, албан бичиг ирүүлээгүй, нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ хийгдээгүй байна.

Гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчидтэй гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй, гэрээний биелэлтэд хяналт тавиагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46-р зүйлийн 46.1.6-д “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих”, мөн ажил гүйцэтгэх гэрээнд тусгагдсан холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байгаа дээрх 3 ажилд алданги тооцохоор шийдвэрлэлээ.

Замын-Үүд сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 7 төсөл арга хэмжээний гэрээний хугацааг сунгасан байна. Гэрээг сунгахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулиар заасан гэрээ сунгах үндэслэлийг харгалзан үзээгүй, гүйцэтгэгч байгууллагын хүсэлтийн дагуу нэмэлт гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №5			
№	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа сунгасан хоног	Ашиглалтанд орсон эсэх
1	Цагдаагийн хэлтсийн гадна дулааны шугам сүлжээг шинээр хийх ажил	15 хоног	Ашиглалтанд орсон.
2	Замын-Үүд сумын 1-р багийн Эрх чөлөөний гудамжны автозамыг асфальтобетон хучилттай болгох ажил	21 хоног	Ашиглалтанд орсон.
3	ЗДТГазрын гадна шугам сүлжээний засвар үүдний заалны засварын ажил	35 хоног	Ашиглалтанд орсон.
4	Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2 давхрын коридорын тохижилтын ажил	40 хоног	Ашиглалтанд орсон.
5	Гэр хороололд цэвэр усны шугам татах ажил	41 хоног	Ашиглалтанд орсон.
6	1-р сургуулиас урагшаа Төмөр замын гал команд хүртэл 410 метр, Дөл буудлын урдуурх 200 метр явган хүний зам барих ажил	60 хоног	Ашиглалтанд орсон.
7	Зөөврийн хогийн бункер	71 хоног	Ашиглалтанд орсон.

3.1.2. Батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан арга хэмжээ байхгүй байна.

**3.2. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл бодитой, хугацаандаа хэрэгжээгүй байхад нийт 450.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.**

3.2.1. Гүйцэтгэгч байгууллагын ирүүлсэн гүйцэтгэлийг ГХБХБГ, Замын-Үүд сумын ЗАА-наас батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг үндэслэн хянадаг хэдий ч гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй ажилласан байна.

3.2.2. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.3<sup>19</sup>, 4.11<sup>20</sup> дах заалтыг зөрчиж дараах ажлуудад нийт 409.7 сая төгрөгийн урьдчилгаа болон үе шатны ажлын санхүүжилтийг гүйцэтгэл бичиж ирүүлээгүй байхад олгожээ. Үүнд:

- *Иргэдийн хөгжлийн төвийн барилгын 40.0 сая төгрөг,*
- *Айраг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын 156.7 сая төгрөг,*
- *Эрдэнэ сумын дулаан, цэвэр бохир шугамын ажлын 213.0 сая төгрөг*

Иххэт сумын нийтийн орон сууцны 6, 7 дугаар байрны дээврийн А нуруунуудыг хөдөлгөөнтэй байсныг бэхлэх, дээврийн муудсан унь модыг шинэчилж солих зэрэг ажлыг магадлашгүй ажлын зардлаар гүйцэтгэхдээ хийгдэх ажлын төсөв, гүйцэтгэлийг гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.12<sup>21</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын хүлээлгийн танхим, архивын өрөөний засварын ажил гүйцэтгэх гэрээний 4.3 дахь заалтын дагуу үлдэгдэл санхүүжилт 70 хувийг ажлаа хийж гүйцэтгэж комисс хүлээн авсны дараа олгоно гэж заасан боловч ажил хүлээж авахаас өмнө 8.1 сая төгрөгийг олгосон байна. Мөн Сум дундын Цагдаагийн хэлтэст 24.0 сая төгрөгийн эргүүлийн автомашин худалдан авах үнийг гэрээний хугацаандаа нийлүүлээгүй байхад шилжүүлсэн байна.

Замын-Үүд сумын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дараах ажлууд огт хийгдээгүй байхад санхүүжилт олгосон бөгөөд ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан Чандмань бадрал ХХК, Говийн жолоо ТББ-ын санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн, иргэн П.Ариун-Эрдэнэ санхүүжилтийг буцааж төлбөр тооцоо хийгээгүй байна. Үүнд:

- *ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний шалыг шинэчлэн засварлах ажилд 2017.07.25-ны өдөр 1.1 сая төгрөг;*
- *ЗДТГ-ын гадна дулааны шугам сүлжээний засварын ажилд 2017.10.03-ны өдөр 5.0 сая төгрөг;*
- *Улс хоорондын зорчих автомашины очер дарааллын замын хашлага хийх ажилд 2017.12.22-ны өдөр 2.8 сая төгрөг тус тус шилжүүлсэн байна.*

Замын-Үүд сумын ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний шалыг шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгээгүй тул иргэнээр 1.1 сая төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Зохиогчийн хяналт тавьсан талаарх баримт материалаа дутуу ирүүлсэнээс нийтийн эзэмшлийн зам талбай, гэр хорооллын гэрэлтүүлэгийн ажлын 0.7 сая төгрөгийг, Эрдэнэ сумын ЦДАШ-ын ажлын 1.1 сая төгрөгийг захиалагч талаас тус тус олгоогүй байна.

<sup>19</sup> Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна.

<sup>20</sup> Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралт, их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгө дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж ирүүлнэ.

<sup>21</sup> Төсвийн магадлашгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадлашгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно.



Айраг сумын халаалт, цэвэр усны шугамын ажлын гүйцэтгэгч Чандмань-Илч ХХК-д 6.0 сая төгрөг, Сайншанд сумын 4 дүгээр багийн Халуун усны барилгын гүйцэтгэгч Энержипарагон ХХК-д 3.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Үүнийг гүйцэтгэгч компани руу 2018 оны 2,4 дүгээр сард шилжүүлсэн байна.

Иххэт сумын нийтийн орон сууцны засварын ажлын зураг төсвийн үнэ 0.75 сая төгрөгийг Шигота ХХК руу илүү шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.3<sup>22</sup> дахь заалтын дагуу зураг төсвийн үнэ, захиалагч, зохиогчийн хяналтын зардал, ТАХ-ний санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Үүнээс харахад санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагатай холбоотой байна.

### **3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сул, хэрэгжсэн зарим ТАХ-ний ашиглалт хангалтгүй байна.**

3.3.1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46-р зүйлийн Захиалагчийн эрх, үүргийн 1.6 заалтад “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсний дагуу дараах ажлуудад хяналт тавьж ажиллажээ.

Сайншанд сумын 1, 2, 5, 7 дугаар баг, Замын-Үүд сумын 1, 4 дүгээр баг, Иххэт сумын 4 дүгээр багийн нийтийн орон сууцны засварын ажлууд, Сайншанд сумын 2, 4 дүгээр багийн халуун усны барилга болон Өндөр довын усан сангийн барилгын зураг төслийг Шигота ХХК хийж гүйцэтгэсэн ба зохиогчийн хяналт тавих гэрээг ГХБХБГ-тай байгуулсан байна.

Шигота ХХК зохиогчийн хяналтаа барилга, засварын ажлуудад 2-3 удаа тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Замын-Үүд сумын ЗАА-аас захиалагчийн хяналт тавьсан ажлуудаас дурдвал:

- 3-р багт ЦДАШ өргөтгөн тавих, гэрэлтүүлэг хийх ажил;
- Багуудын засварын ажил;
- Цагдаагийн хэлтсийн 2 давхрын коридорын тохижилтын ажил, гадны дулааны шугам шинээр хийх ажил, дотор шугам сүлжээг хэсэгчлэн шинэчлэх ажил;
- 1-р багийн Эрх чөлөөний гудамжны автозамыг асфальтобетон хучилттай болгох ажил;
- 1-р цэцэрлэгийн дулааны шугам шинээр татсан ажил;
- 1-р сургуулиас урагш 410м, Дөл буудлын урдуурх 200м явган хүний зам барих ажил.

3.3.2. Замын сангийн хөрөнгөөр Сайншанд суманд суурилуулах камерийн ажлыг 314.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр Савамонтаж ХХК шалгарсан байна. Аймгийн Цагдаагийн газрын телекамерын хяналтын төвд ашиглагдаж байгаа 69 камернаас 58 камер байнгын хэвийн ажиллагаатай, үлдсэн 11 камер нь хэвийн бус, үйл ажиллагаа нь доголдолтой байна.

<sup>22</sup> Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.

Тухайлбал: Нарлаг шандын зам руу чиглэсэн камерийн тусгал нь замын байршлыг харуулаагүй, замын хажуугийн гуу, жалгыг харуулсан, автомашины улсын дугаар илрүүлэг камер нь заримдаа огт ажилладаггүй, доголддог, цаг агаарын нөхцөл байдал болон гэрэл тасарсан үед ямар ч шалтгаангүйгээр бичлэг бичдэггүй, эсвэл бичлэгээ тасалж бичдэг зэрэг зөрчлүүд илэрч байна. Мөн татдаг камерийн гар удирдлага огт ашиглагддаггүй байна.

Аймгийн ЗДТГ-аас Саватонтаж ХХК-ийг шалгуулахаар Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу ажлыг бүрэн гүйцэтгүүлж хүлээн авах, хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах албан шаардлага бичив.

Замын-Үүд суманд Оточ буян ХХК багц 2-т зарлагдсан 1, 4 дүгээр багийн 114, 115, 109 дүгээр байрны нийтийн орон сууцны засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 114, 109 дүгээр байрны засварын ажлыг гүйцэтгэхдээ ханын будгийн доорх гадаргууг муу өнгөлснөөс ханын будаг тогтохгүй хууларсан, ханын хөөсөн хавтангийн нягт бага байгаагаас шалтгаалан ховхорсон байдалтай байна. Оточ буян ХХК-аар чанаргүй ажлыг дахин засварлуулах албан шаардлага бичив.

Сайншанд сумын 4 дүгээр багт байрлах Усан сангийн худаг, Халуун усны барилгыг улсын комисс ашиглалтанд хүлээлгэн өгсөн боловч өнөөг хүртэл хөрөнгийн ашиглагч байгууллага тодорхой бус, ашиглалтгүйгээс барилгын цонх хагарсан, гадна талын үүдний хэсгийн цоколь унасан байдалтай байгаа нь уг хөрөнгийн үр ашиг, өгөөжийг бууруулж байна. Усан сан, халуун усны барилгын ашиглагч байгууллагыг шийдвэрлэх, данс бүртгэлд тусгах, хөрөнгийг ашиглаж хэвийн үйл ажиллагаатай болгох албан шаардлага бичив.

3.3.3. Сайншанд сумын 6 дугаар багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилгыг улсын комисс ашиглалтанд хүлээлгэн өгсөн боловч зарим бичиг баримт дутуугаас шалтгаалж данс бүртгэлд тусгаагүй байна. Баримт материалыг бүрдүүлж хөрөнгийг данс бүртгэлд тусгах албан шаардлага бичив.

#### Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт:

Өмнөх аудитаар 9 зөвлөмж өгөгдсөнөөс дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

1. Хөрөнгийн үр ашиг, үр өгөөж, үр дүнд хүрэх тооцоо, ТАХ-ний хяналтын төсөв, зураг төсөл бүрэн эсэхийг нягталж хөрөнгө оруулалтын төсөв батлах;
2. Төсвийн тухай хуулийн 4.1.24-т заасан "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасныг анхаарч төсөв батлах;
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлага, эдийн засаг, үйл ажиллагаа, цаг хугацааны хувьд хэрэгжих боломж байгаа эсэх, үр өгөөж, үр нөлөөг тооцож үнэлгээ хийн төрийн захиргааны байгууллага болон аймгийн ИТХ-д хүргүүлэх;
4. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах;
5. ТАХ-ний гүйцэтгэлийн үе шат бүрт шат шатны хяналтыг хэрэгжүүлэх, чанартай гүйцэтгүүлэх, батлагдсан хугацаанд ашиглалтад хүлээн авахад анхаарч ажиллах;
6. Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний нөхцөлийг тодорхой тусгаж, гэрээг дүгнэж ажиллах.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Тухайн онд хэрэгжих ТАХ-г аймгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдуулан баталсан байна.

Зураг төсвийг бүрэн хийлгээгүй, үр ашигтай эсэх нь тодорхой бус ТАХ-нд төсөв баталсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр ашгийг бууруулж байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад 747.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил төлөвлөсөн нь төсвийн тухай хуулиар заасан орон нутгийн төсвийн чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

Төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ямар байгууллага эзэмшиж ашиглах, үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх урьдчилан судлаагүйгээр төсөв батлуулжээ.

Зураг төсөлгүй батлагдсан төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг тендер зарлагдсан ажлын үнийн саналд нэмж тусгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний захиалагч, гүйцэтгэгч талуудын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавиагүй байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээ чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ТАХ-ний ашиглагч байгууллага тодорхой бус, ашиглалт хангалтгүй, 460.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар нийт 3,902.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 23.8 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 480.5 сая төгрөгийн 6 албан шаардлага бичиж 3,926.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

### Аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр танаа:

1. Хөрөнгийн үр ашиг, үр дүнд хүрэх тооцоо, хөрөнгө оруулалтын ажлын хяналтын төсөв, зураг төсөл бүрэн төсөл арга хэмжээнд төсөв батлах.
2. Төсвийн тухай хуулийн 4.1.24-т заасан "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасныг анхаарч төсөв батлах.

### Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний батлагдсан зураг төсөл, хөрөнгийн хэрэгцээ шаардлага, үр өгөөжийг тооцон төлөвлөж ИТХ-д санал оруулах.
2. Төсөл арга хэмжээний гэрээний биелэлтийг хангуулж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож ажиллах.

### Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг танаа:

1. Гэрээнд тусгагдсаны дагуу ТАХ-ний үе шатны ажлын явц, хэрэгжилтэнд тавьж буй захиалагчийн хяналтын чанарыг сайжруулах.
2. Төсөл арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд ашиглалтанд оруулж, данс бүртгэлд тусгах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



## ДОРНОГОВЬ АЙМАГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
Утас/факс: (705) 2-31-40

2018.06.14 № 256

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн “Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.


Аймгийн ИТХ-аас Төсвийн хуулийг хэрэгжүүлж ажиллахад онцгой анхаарч байгаа бөгөөд тайланд тусгасан зөвлөмжийг хүлээн авч байна.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй бөгөөд цаашид орон нутгийн төсвийн төлөвлөлтөд хөрөнгийн үр ашигтай, тооцоо судалгаатай, хяналтын төсөв, зураг төсөл нь бүрэн арга хэмжээг тусгаж байхын тулд зарим ажлуудыг зохион байгуулахаар ажиллаж байна. Үүнд:

- Дараа оны төсвийн төсөл боловсруулах удирдамж, төсвийн төслийг төлөөлөгчдөд цаг тухайд нь танилцуулах, тэдэнд мэдлэг ойлголт өгөх
- Төсвийн төсөл боловсруулах үе шатуудад төлөөлөгчид болон холбогдох байгууллагуудаас шаардлага хангасан төсөл арга хэмжээг тусгах талаар мэдээлэл өгөх
- Төсөв батлах хуралдаан болохоос өмнө төлөөлөгчдийг хороодоор урьдчилан ажиллуулан, төсөл арга хэмжээнд тавигдах шаардлагуудыг хангасан эсэхээр дүгнэлт гаргуулах
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид санал шаардлага тавих

Түүнчлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.06.07-ны өдрийн “Хяналт шалгалтын ажил зохион байгуулах тухай” 46 дугаар тогтоолоор хороодын хяналт шалгалтын ажлын хэсэг гарч улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж буй төсөл арга хэмжээнд хөндлөнгийн хяналт шалгалтын ажил хийн газар дээр үзэж шалгаж ажиллахаар шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд танай байгууллагын аудитын тайланг мөн баримт болгон ашиглаж холбогдох санал дүгнэлтийг гарган ажиллах болно.

НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ





ДОРНОГОВЬ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон,  
Утас/факс: (705) 2-30-03  
E-mail: domogobi\_mgl@yahoo.com

2018.06.18 № 3/1146

танай 2018.06.11-ны № 1-6/468 -Т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайланд өгөх саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ...6..... хуудастай.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ



D:\2018\ZAH-TOOT



“Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланд өгөх санал

2018.06.13

**“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”**

1.1.2. Монгол Улсын Ерөнхий сайд болон салбар яамдын сайд нартай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний дагуу зарим агентлагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Санхүүгийн дэмжлэг хүссэн байгууллага бүрт дэмжлэг өгөөгүй, судалж үзээд зайлшгүй шаардлагатай, нэн чухал хэрэгцээтэй байгууллагад санхүүгийн дэмжлэг олгосон болно. Тухайлбал: аймгийн Цагдаагийн газарт хурд хэмжигч худалдан авахад 29.2 сая төгрөг, цагдаагийн пост барихад 69.1 сая төгрөг г.м /санхүүгийн дэмжлэг үзүүлснээр гэмт хэргийн гаралт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй гарсан./

1.2.1. Тухайн үед зураг төсөл нь бэлэн болоогүй экспертизээр батлагдаагүй 3 төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулсан боловч одоо зураг төсвийг хийлгэж, магадлангаар баталгаажуулсаныг Аудитын газарт хүргүүлсэн болно. Үүнд: Сайншанд сумын 6-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга, Усан спорт сургалтын төвийн барилга, Эрдэнэ сумын ААНБ, айл өрхийг нэгдсэн халаалт, цэвэр бохир усны шугамд холбох ажил-/зургийг магадлангаар сая баталгаажуулсан/

3.1.1. Замын-Үүд сумын ИТХ-ын 2017 оны 07/01 тоот тогтоолын 2-р хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад Хилийн 0108-р ангийн спорт заалны шал хийх ажлыг 48.0 сая төгрөгөөр хийхээр баталжээ. Замын-Үүд сумын Төрийн сангийн даргаас тайлбар авахад Хилийн 0108-р анги нь анх спорт заалны шал хийнэ гэж саналаа өгсөн гэх боловч албан бичиг нь олдохгүй байна гэсэн тайлбар өгсөн.

3.1.2. Хөвсгөл сумын ЗДТГ-ын автомашин худалдан авах ажиллагаанд оролцох компани олдохгүй байсан учир шууд гэрээ байгуулж худалдан авсан байна. Хөвсгөл сумын Засаг даргаас тайлбар авахад Тендерийн бичиг баримтанд заасан шаардлагыг хангасан автомашин худалдан авахад 60.0 сая төгрөгийн үнэтэй байсан гэсэн тайлбар өгсөн.

2.1.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа барилга угсралт, их засвар, тохижилтын ажлын зураг төслийн зардлыг тендерийн үнийн саналд тусгуулж байгаа нь Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12 нийцэж байгаа болно. Үүнд:

“Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/-ийн 4.11/Захиалагчийн мэдлийн зардал нь газрыг ашиглах, эзэмшихтэй холбогдсон зардал, инженер хайгуул, зураг төслийн зардал, захиалагчийн хяналтын зардал, зөвлөх үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт, магадлагчгүй ажил зэргээс бүрдэнэ. Эдгээр зардал нь захиалагчийн мэдэлд байх бөгөөд гүйцэтгэл зардлыг үндэслэн холбогдох тооцоог хийнэ/, 5.16 /Зураг төсөл, инженерийн хайгуулын ажлын зардлыг холбогдох норм, дүрмийн дагуу тооцно./ 6.33 /Үйлдвэрлэлийн болон орон сууц иргэний барилгын нэгдсэн төсвийн тооцоог дараах бүлгүүдээр хуваарилна . 1. Барилгын талбай бэлтгэх, ... 12. Зураг төсөл, хайгуулын зардал/, 6.44 /12 дугаар бүлэгт дараах ажлуудыг



гүйцэтгэхтэй холбогдон гарах хөрөнгийн хэмжээг тусгана: Барилгын инженер хайгуулын ажлын зардал, Зураг төслийн ажлын зардал, Барилгад тавих зохиогчийн хяналтын зардал/ дэх заалтуудтай нийцэж байгаа болно.

Өмнөх жилүүдэд орон нутгийн төсөвт зураг төслийн ажлын зардлыг тусад нь төлөвлөж нилээдгүй барилгын ажлын зураг төслийг хийлгэсэн боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй гэсэн шалтгаанаар барилгууд нь баригдаагүй, зураг төсөлд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь аудитын шалгалтаар илэрч байсан. Бид энэ алдааг давтахгүй нь тулд нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр нь батлагдах нь тодорхой болсон барилгуудын зураг төслийг мэргэжлийн эрх зөвшөөрөл бүхий байгууллагаар урьдчилан гүйцэтгүүлж зардлыг тендерийн төсвийн үнийн саналд тусгуулж байгаа болно.

3.2.2. Иххэт сумын нийтийн орон сууцны 6, 7, 8 дугаар байрны дээврийн А нуруунуудыг хөдөлгөөнтэй байсныг бэхлэх, дээврийн муудсан унь модыг шинэчилж солих зэрэг ажлыг магадлашгүй ажлын зардлаар гүйцэтгүүлсэн бөгөөд тухайн ажлын нийт төсөвт өртөг нь 3.1 сая төгрөг гарсан бөгөөд гүйцэтгэлийг хянахдаа төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардлын дүнд багтаан зөвхөн материалын үнээр тооцоог гаргаж хавсаргасан болно.

3.3.3. Сайншанд сумын 6 дугаар багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилгын холбогдох баримт бичгийг бүрдүүлж ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгуулахаар хүргүүлээд байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлсэн Сайншанд сумын 4 дүгээр багийн халуун усны барилга, Айраг сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, Эрдэнэ сумын 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станц барих ажлууд нь гэрээт хугацаандаа бүрэн дууссан болох нь дараах баримт материалаар нотлогдож байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын тамгын газар болон “Энержи парагон” ХХК-ийн хооронд байгуулсан Сайншанд сумын 4-р багийн Халуун усны барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тухай 2017.06.29-ны өдрийн ОНХО-ХА-02/2017 дугаартай гэрээний дагуу барилгын ажлыг 2017.07.03-ны өдрөөс эхэлж, 2017.08.18-ны өдөр ашиглалтад оруулахаар тохиролцсон байна. Гүйцэтгэгч компани нь барилга угсралтын ажлыг гэрээт хугацаандаа бүрэн дуусч комисс ажиллуулах хүсэлтийг аймгийн Засаг даргын тамгын газарт 2017.08.18-ны өдрийн 91 тоот албан бичгээр гаргасан байна.

2. Аймгийн Засаг даргын тамгын газар болон “Уртын-Уул” ХХК-ийн хооронд байгуулсан Эрдэнэ сумын 0.4 кВ-ын ЦДАШ, дэд станц барих ажлыг гүйцэтгэх тухай 2017.09.20-ны өдрийн ОНХС-НТШ-07/2017 дугаартай гэрээний дагуу барилгын ажлыг 2017.09.20-ны өдрөөс эхэлж, 2017.10.20-ны өдөр ашиглалтад оруулахаар тохиролцсон байна. Гүйцэтгэгч компани нь ЦДАШ, дэд станцын угсралтын ажлыг гэрээт хугацаандаа бүрэн дуусч техникийн комисс ажиллуулах хүсэлтийг ГХБХБГазарт 2017.10.16-ны өдрийн 45 тоот албан бичгээр гаргасан байна.

3. Аймгийн Засаг даргын тамгын газар болон “Дархан харуул” ХХК-ийн хооронд байгуулсан Айраг сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тухай 2017.05.12-ны өдрийн ШГ-08/2017 дугаартай гэрээний дагуу барилгын ажлыг 2017.05.12-ны өдрөөс эхэлж, 2017.10.01-ний өдөр ашиглалтад оруулахаар тохиролцсон байна.

Өргөтгөлийн барилгын халаалт, цэвэр ус, бохир усыг хуучин эмнэлгийн барилгын шугам сүлжээнээс салбарлаж шууд холбохоор төлөвлөж байсан боловч ажлын явцад ашиглагч байгууллагын хүсэлтээр тусдаа оруулгатай байхаар шийдвэрлэж “Чандмань-Илч” ХХК-аас 2017

оны 341 дугаартай албан бичгээр техникийн нөхцөл гаргуулан нэмэлтээр гадна шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд барилгын ажил 1 сараар хойшилж 2017.11.01-ний өдөр техникийн комисс ажилласан байна.

Иймд дээр дурьдсан ажлуудыг гүйцэтгэсэн компаниудад гэрээний алданги ногдуулахгүй байх саналыг хүргүүлж байна.

Жич: Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны тайлбарыг хавсаргав.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналыг хүлээн аваад дараах тайлбарыг өгч байна.

1.1.2-ын хариу: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагад хөрөнгө худалдан авахад зориулж 140.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төсөв баталсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтыг зөрчиж байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

1.2.1-ийн хариу: Аудитын тайлангийн 1.2.1 дэх хэсгийг “Аймгийн ИТХ-аар зураг төсөл нь бэлэн болоогүй, зураг төсөл нь экспертизээр батлагдаагүй 3 төсөл арга хэмжээнд 2,138.4 сая төгрөгийн төсөв батлуулсан байна” гэж өөрчлөн оруулав.

3.1.2-ын хариу: Хөвсгөл сумын ЗДТГ-ын автомашин нь тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн тодорхойлолтын зарим үзүүлэлтийн шаардлагыг хангаагүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

2.1.1-ийн хариу: Аудитын тайлангийн 2.1.1 дэхь хэсэгт өөрчлөлт оруулж хассан болно.

3.2.2-ын хариу: Сангийн сайдын 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.12-д “Төсвийн магадлашгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадлашгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно” гэж заасан байхад хийгдэх ажлын төсөв, гүйцэтгэл гаргаагүй байхад магадлашгүй ажлын зардлыг олгосон тул тайлангийн хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

3.3.3-ын хариу: Аудитаар тус барилгыг бүртгэлд тусгахаар албан шаардлагыг өгсөн.

Аудитын тайланд бичигдсэн “Гэрээний хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчидтэй гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй, гэрээний биелэлтэд хяналт тавиагүй байна. Иймд дээрх 6 гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн хугацаа хэтэрсэн хоног тутамд алданги тооцуулахаар ГХБХБГ-т хариуцуулж албан шаардлага бичлээ” гэсэн хэсгийг “Ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй байгаа 3 ажилд алданги тооцохоор шийдвэрлэлээ” гэж өөрчлөн орууллаа.

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн саналыг хүлээн аваад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.





ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/16

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.12, 15.2.2, 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам", 2017 оны 188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр ашиг, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ц.Лүндэгмаа/-д үүрэг болгосугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

9825883